

## ТӨВД ҮНДЭСТЭНИЙ ТУХАЙ

### Ш.Догмийчойдон\*

БНХАУ-ын Төвдийн Өөртөө Засах Орон(ТӨЗО)-д төвд, хятад, хүд, монбо, ло, монгол, уйгур зэрэг 26 орчим үндэстэн, бас ямар нь үл мэдэгдэх дорно зүгийн хүмүүс ч байдаг. Хятад ба хүд үндэстэн нь голдуу суурин газар хот, тосгонд амьдрах бөгөөд бусад үндэстэнүүд нь хот хөдөөгүй таран суудаг.

ТӨЗО-ны нийт хүн амын 94 гаруй хувийг төвд үндэстэн эзэлдэг хийгээд БНХАУ-ын Юньнань муж болон ТӨЗО-нд төвд үндэстэн голлон амьдардаг байна. Эртний Цин, Хан (МЭӨ 221-220) улсын өмнөх үеэс төвд үндэстэний эцэг өвгөд Ярлүн (Ялун) мөрний дунд хэсэгт оршин суух болжээ. Голдуу мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг бөгөөд буудай, гич, буурцаг зэргийг тарьдаг байв. Арвай ба буурцагыг хуурч, тээрэмдсэн гурил, хонины хатаасан борц, тос, арвайн нэрмэл зэрэг нь төвд үндэстэний гол хоол хүнс юм.

Төвд үндэстэн нь өөрийн гэсэн хэл, бичигтэй. Төвд хэл нь Хятад-төвд хэлний язгуурт багтах бөгөөд До (mdo), Үй (dbus), Хам (khams) гэсэн 3 янзын нутгийн аялгуутай. МЭ-ын VIII зууны дунд үед Төвдийн хаан Сронзангамбо зарлиг буулгаж Нүв (nub), Жагарын орны бичиг үсэгт тулгуурлан “Гамад сүмжү” (kamad-sum-cu) хэмээх гучит буюу цагаан толгойг зохиолгожээ. Түүнээс эхэлж төвдүүд өөрийн бичиг үсгийн дүрэмтэй болсон буй. МЭ-ын VIII зуунд Төвдөд яруу найраг асар их дэлгэрчээ. Х-ХҮI зуунд Төвдийн бичгийн соёл машид хөгжиж “Гаадан” (bka'-bstan, зарлиг номлол), “Гэсэрийн домог” зэрэг олон алдарт зохиол гарчээ.

Төвдүүд олон үс оруулга, унжлага чимэглэлтэй хувцас өмсөх бөгөөд эрэгтэйчүүд нь үсээ ардаа бооно. Төвдүүд ноосон нөмрөг өмсөхдөө 2 мөрөө гадагш нь мулталж, 2 ханцуйгаа бэлхүүсээрээ ороож өмсдөг. Мөн урт түрийтэй гутал өмсөж бүсэндээ хутга зүүдэг. Эмэгтэйчүүд нь үсээ хоёр тийш нь самнаж мана, шүр, оюу, гартаам зэрэг эрдэнээр чимсэн толгойн чимэглэл зүүдэг. Нутаг нутгийн амьдрал ахуй өөр байдгийн эрхээр хувцасны загвар

\* Ш.Догмийчойдон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

нь ч янз бүр байх бөгөөд газар тариалан эрхэлдэг нутгийн эрэгтэйчүүд зах нь их уужуу, баруун хормой нь задгай нэхмэл хувцас өмсөнө. Эмэгтэйчүүд нь том захтай, ханцуйгүй ноосон нөмрөг өмсөж, хээ угалзаар чимэглэсэн хормогч зүүнэ. Мал аж ахуй эрхэлдэг нутагт эр, эм ялгалгүй бүгдээрээ үргэлж хонины арьсан дээл өмсдөг.

Төвд үндэстэний жирийн малчид нь хар эсгий майханд, тариачид туйпуу болон чулуугаар барьсан хананы дээр тэгшхэн дээвэр хийж дээд талд нь өөрсдөө амьдарч, доод талдаа хонь малаа оруулдаг. Суурин газарт амьдрагчдын олонхи нь орон сууцанд амьдардаг. Сүүлийн жилүүдэд угсармал барилгад амьдрагчид өдөр ирэх тутам улам бүр нэмэгдэж байна.

Төвдүүдийн ихэнхи нь буддын шашныг шүтэн биширдэг. Буддын сүм хийд Төвд орны орон нутаг бүрд байдаг бөгөөд Брайбүн, Сэра, Дашлхүнбо зэрэг алдартай сүм хийд олон байдаг. Сүсэгтнүүдийн гэрт тахилын сав байх бөгөөд хүзүүндээ сахиус зүүж, хүрд эргүүлэн тахил шүтээндээ мөргөдөг. Төвдийн шинэ жил, намрын тарагны баяр зэрэг уламжлалт баярын үед болон оршуулгын зан үйлийн үед төвдүүд мөргөл их үйлддэг.

Төвд үндэстэний дуу, бүжиг нь их онцлогтой бөгөөд дуут бүжиг, тойрон бүжиг зэрэгт төвдийн үндэсний онцлог их илэрч байдаг.